



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 15

Мандалговь

**Үндсэн хөрөнгө бүртгэх, автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газарт худалдан авсан 125,000,000 /нэг зуун хорин таван сая/ төгрөгийн үнэтэй TOYOTA Land Cruiser 150 Prado маркийн автомашиныг нэгдүгээр хавсралтаар үндсэн хөрөнгөд бүртгэх, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20,000,000 /хорин сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй ДУА 50-66 улсын дугаартай УАЗ-315122 маркийн автомашиныг хоёрдугаар хавсралтаар худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга /С.Болоржаргал/-д даалгасугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бэхлэх бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Н.Бадамцэцэг)-т даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 2.1 дүгээр сарын
12 өдрийн 13. тогтоолын нэгдүгээр хавсралт

1. Сайхан-овоо сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэх тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өргөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	Toyota. Land Cruiser 150 parado	ДУН	00-04	2019	2020.07.07	JTEBX9FJ00K 322923		2694	0	125,000,000	-	-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 2-р дүгээр сарын
16-р өдрийн 16. тогтоолын хоёрдугаар хавсралт

2. Сайхан-овоо сумын Эрүүл мэндийн төвийн тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Серийн дугаар	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	UAZ 315122	ДУ А	50-66	2009	2009.08.01	90539190	90002634	2445	264,776	20,000,000	20,000,000	-